

БАТЛАВ.  
ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Д.АНХБАЯР

2018.05.07

Булган

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Аудитын нэр

“16 сум болон 1 тосгоны ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл”.

### 2. Аудитын код

БУА-2018-01-НА

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### 4. Аудитын зорилт:

Сумдын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж үнэлэлт өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршино.

### 5. Аудитын хамрах хүрээ

Сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, хувиарлалт, зарцуулалт, ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагааг хамруулна.

### 6. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн.

### 7. Аудитын арга зүй:

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

### 8. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 11 сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Холбогдох бусад хууль, тотоомж

#### **9. Аудит хийх хугацаа:**

Аудитыг аймгийн Аудитын газрын удирдамжаар Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр, аудитын менежер Ж.Энхцоодол удирдаж, аудитор Д.Даариймаа 2018 оны 05 дугаар сарын 07-ноос ажлын 30 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.

#### **10. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц**

Санхүүгийн нөөц: цалингийн зардал-893000

Техник хэрэгсэл: Компьютер, принтер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА